



МОНГОЛ УЛСЫН
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙДЫН
ТУШААЛ

2025 оны 02 сарын 24 өдөр

Дугаар А/60

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.10 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Дотоод, гадаадын цэргийн академи, сургууль, дамжаанд суралцаж байгаа сонсогч, суралцагчид цалин хөлс олгох журам"-ыг хавсралтаар баталж, 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдсүгэй.

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (хурандаа Б.Эрхэмбаяр)-т даалгасугай.

САЙД



С.БЯМБАЦОГТ

1325100094

Батлан хамгаалахын сайдын 2025 оны

дугаар сарын 14-ны өдрийн
дугаар тушаалын хавсралт

**ДОТООД, ГАДААДЫН ЦЭРГИЙН АКАДЕМИ, СУРГУУЛЬ, ДАМЖААНД СУРАЛЦАЖ
БАЙГАА СОНСОГЧ, СУРАЛЦАГЧИД ЦАЛИН ХӨЛС ОЛГОХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Дотоод, гадаадын цэргийн академи, сургууль, дамжаанд суралцагчид цалин хөлс олгохтой холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2.Төрийн албаны тухай хууль, Монгол Улсын Батлан хамгаалах тухай хууль, Зэвсэгт хүчний тухай хууль, Цэргийн албаны тухай хууль, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, энэ журмыг баримтална.

Хоёр.Сургууль, дамжаанд суралцагчид цалин хөлс олгох

2.1.Яамны Төрийн захиргааны удирдлагын газар (цаашид "ТЗУГ" гэх) нь жил бүр энэ журамд заасан суралцагчийн цалин хөлс, тээврийн болон байр ахуйн зардал тооцоог нэгтгэж, яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газарт хүргүүлнэ. Яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газар нь уг зардлыг Батлан хамгаалах яамны тухайн жилийн төсөвт суулгах арга хэмжээ авна.

2.2.Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9.5-д заасны дагуу дотоод, гадаадын цэргийн их, дээд сургууль, академи, коллеж болон эрдэм шинжилгээ судалгааны чиглэлээр суралцаж байгаа суралцагч (цэргийн алба хаагч, ажилтан албан хаагч)-д цалин хөлс олгоно.

2.3.Дотоод, гадаадын цэргийн сургууль, академид суралцаж байгаа суралцагчийн цалин хөлсийг доор дурдсанаар тооцож сар бүр олгоно. Үүнд:

2.3.1.ОХУ-ын цэргийн их, дээд сургууль, академи, коллеж, 6 сараас дээш хугацааны мэргэшүүлэх болон албан тушаалын сургалтад суралцаж буй офицер, ахлагч нарт суралцахаас өмнө эрхэлж байсан албан тушаалын үндсэн цалинг 100 хүртэлх хувиар, цолны цалин, төрийн тусгай алба хаасан хугацааны нэмэгдлийг тооцон олгоно;

2.3.2.ОХУ-ын цэргийн их, дээд сургуулийн бакалаврын болон дипломын сургалтад хамрагдаж буй ахлагч, сонсогчид тухайн жилд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй цалингийн сүлжээний ТТ-12 дахь зэрэглэлээр үндсэн цалинг 100 хүртэлх хувиар, цолны цалинг тооцон олгоно;

2.3.3.Энэ журмын 2.3.1, 2.3.2-т зааснаас бусад гадаад улсын цэргийн их, дээд сургууль, академи, коллеж, 6 сараас дээш хугацааны мэргэшүүлэх болон албан тушаалын сургалтад суралцаж буй офицер, ахлагч нарт суралцахаас өмнө эрхэлж байсан албан тушаалын үндсэн цалинг 80 хүртэлх хувиар, цолны цалин, төрийн тусгай алба хаасан хугацааны нэмэгдлийг тооцон олгоно;

2.3.4.Энэ журмын 2.3.3-т зааснаас бусад гадаад улсын цэргийн их, дээд сургуулийн бакалаврын болон дипломын сургалтад хамрагдаж буй офицер, ахлагч, сонсогчид тухайн жилд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй цалингийн сүлжээний ТТ-12 дахь зэрэглэлээр үндсэн цалинг 80 хүртэлх хувиар, цолны цалинг тооцон олгоно;

2.3.5 Гадаадын цэргийн академи, их дээд сургуульд суралцаж байгаа офицер, ахлагч, сонсогч нарт суралцах хугацааны цалин хөлсийг олгохдоо сургалтын дүнг харгалзан дараах байдлаар олгоно.

Д/д	Улс, орон	Сурлагын дүн (Цалин, хөлс олгох хувь хэмжээ)			Цалин олгох хувьд хамаарах үнэлгээ
		Онц	Сайн	Дунд	
		А	В	С	
Цэргийн академи, коллеж, их, дээд сургууль (Магистр)					
1	Оросын Холбооны Улс	100%	80%	60%	Өмнөх жилийн эцсийн сурлагын үнэлгээ эсвэл өмнөх улирлын сурлагын үнэлгээ
2	Бусад гадаад улс	80%	60%	40%	
Цэргийн их дээд сургууль (бакалавр)					
1	Оросын Холбооны Улс	100%	80%	60%	Өмнөх улирлын сурлагын үнэлгээ
2	Бусад гадаад улс	80%	60%	40%	

Жич: Дунд (С)-аас доош үнэлгээтэй суралцсан бол цалин хөлс олгохгүй, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр нийгмийн даатгалын шимтгэлийг төлнө.

2.3.6.Гадаадын их, дээд, сургуульд 6 сараас дээш хугацаагаар албан тушаалын болон мэргэшүүлэх сургалтад захиалгаар суралцаж байгаа ажилтан албан хаагчид суралцах хугацаанд холбогдох хууль, дүрэм журмын дагуу цалинг олгоно;

2.3.7.Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн Цэргийн нэгдсэн дээд сургуулийн сонсогчид тухайн жилд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй цалингийн сүлжээний ТТ-12 дахь зэрэглэлээс цэргийн цолны цалинг Засгийн газрын тогтоолоор тогтоосон хувиар тооцон олгоно;

2.3.8.Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн Батлан хамгаалах удирдлагын академид суралцаж буй офицерт тухайн жилд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй цалингийн сүлжээний ТТ-6 зэрэглэлээр үндсэн цалин болон цолны цалин, төрийн тусгай алба хаасан хугацааны нэмэгдлийг тооцон олгоно.

2.3.9 Гадаад, дотоодын академи, цэргийн их дээд сургуульд болон урт хугацааны дамжаанд суралцаж буй офицер, ахлагч, сонсогчдын мэдээллийг Төрийн захиргааны удирдлагын газар сар бүр тодотгон БХЯ, ЗХЖШ-ын ҮААХ-т хүргүүлнэ.

2.4.Төрийн албаны тухай хуулийн 61.1.7-д заасны хүрээнд 6 хүртэлх сарын хугацаагаар давтан сурах, мэргэшлээ дээшлүүлэх сургалтад хамрагдаж байгаа бол энэ хугацаанд эрхэлж байгаа албан тушаалын цалинг нь анги байгууллага олгоно.

2.5.Гадаадын цэргийн сургууль, дамжаанд суралцагчийн ирэх, буцах тээврийн зардлын тооцоог яамны ТЗУГ гаргаж, зардлыг олгох асуудлыг Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штабын Үйлчилгээ, аж ахуйн хэлтэс хариуцна.

2.6.ОХУ, БНХАУ зэрэг улсад суралцах цэргийн алба хаагч, иргэнийг суралцахаар явах эхний жилд нэгдсэн байдлаар газраар (галт тэрэг, автомашин) тээвэрлэх зохион байгуулалтын арга хэмжээ авна.

2.7.Энэ журмын 2.6-д зааснаас бусад гадаадын цэргийн сургууль, академи, сургалт, дамжаанд суралцаж буй суралцагчийн ирэх, буцах тээврийн зардлыг тухайн үед мөрдөгдөж байгаа нисэх онгоц, галт тэрэг, автомашинаар зорчсон баримтыг үндэслэн (энгийн зэрэглэлээр) тооцож жил бүр олгоно.

2.8.ОХУ-ын цэргийн академид суралцаж буй офицер нь тухайн улсад суралцах хугацаандаа амьдарч буй байрны зардлыг хувиасаа төлсөн анхан шатны баримтыг Батлан хамгаалах яаманд (БХЯ, ЗХЖШ-ын ҮААХ) цахимаар ирүүлсэн тохиолдолд тус баримтыг үндэслэн улирал бүр суралцагчийн дансанд шилжүүлнэ. Хэрэв анхан шатны баримтаар нотлогдоогүй бол байр, ахуйн зардлыг олгохгүй.

2.9.Гадаадын бусад улс орны Засгийн газар, батлан хамгаалах яамтай байгуулсан боловсон хүчнийг сургах тухай гэрээ, хэлэлцээрт сургалтын зардал, цалин хөлс, эдлэх хөнгөлөлт, тээвэр, байр ахуйн зардал, тэтгэлэг болон бусад хангалтыг зохицуулахаар тусгасан бол тухайн гэрээ, хэлэлцээрийг баримтална.

2.10.ОХУ-ын цэргийн сургууль, академид суралцаж буй суралцагч нь суралцаж байх хугацаандаа эрүүл мэндийн урьдчилсан сэргийлэх үзлэгт хамрагдсантай холбогдон гарах зардлыг хоёр талын хооронд байгуулсан гэрээ, хэлэлцээрийн дагуу суралцагчид нөхөн олгож болно.

2.11.Хоёр улсын хооронд байгуулсан гэрээ, хэлэлцээрийн дагуу ҮБХИС-ийн Батлан хамгаалахын удирдлагын академид суралцаж буй гадаад улсын суралцагчид сар бүр 2 сая төгрөгийг байр ахуйтай холбогдон гарах тэтгэмжээр олгож болно.

2.12.Гадаад улсын суралцагчийн суралцах хугацааны байр, ахуйтай холбоотой амьжиргааны зардлыг 2.11-т заасан тэтгэмжээс суутган тооцож болно.

2.13. Гадаад, дотоодын цэргийн их дээд сургуульд суралцаж байгаа офицер, ахлагч, сонсогчийн нийгмийн даатгалын тайлан, хувь хүний орлогын албан татварын тайланг тус тус хуулийн хугацаанд гарган холбогдох байгууллагад

хүргүүлнэ.

2.14.Суралцагч сургалтын хугацаанд нас барсан тохиолдолд түүний шарилыг эх оронд нь авч ирэхтэй холбогдон гарах зардлыг талуудын хооронд байгуулсан гэрээний холбогдох заалтыг үндэслэн Батлан хамгаалах яам шийдвэрлэнэ.

2.15.Хоёр талын гэрээ, хэлэлцээр болон батлан хамгаалах салбарын тухайн жилийн төсөвт өөрчлөлт орсон тохиолдолд энэ журамд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

2.16.Энэхүү журмыг зөрчсөн албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---